



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Архангай аймгийн Цагдаагийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: АРА-2022/27/-НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Архангай аймаг 2022 он</p>	<p>Дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа Утас: 7033-3141 Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn Аудитын менежер Д.Нэргүйбаатар Утас: 7033-2860 Цахим хаяг: Nerguibaatar@audit.gov.mn Аудитор П.Энхжаргал Утас: 9974-3112 Цахим хаяг: EnkhjargalP@audit.gov.mn</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.Аудитын санал дүгнэлт	2
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	3
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	3
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	7
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	9
3. Аудитын тайлан.....	9
3.1 Ерөнхий зүйл.....	9
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	10
3.4 Материаллаг байдал	11
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	11
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	12
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	13
3.8 Аудитын гол асуудал	13
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	13
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	14
3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд.....	14
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	14
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	14

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЦЕГ	Цагдаагийн ерөнхий газар
ЦБҮАЖ	Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам

1. Аудитын санал дүгнэлт



АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

65130 Цэцэрлэг, Архангай аймаг
Утас/Факс: 976-70333141
И-мэйл: arkhangai@audit.gov.mn

2022.02.18 № 19
танай _____ -ны № _____ -т

ЦАГДААГИЙН ГАЗРЫН ДАРГА

А.ЛХАГВАДОРЖ ТАНАА

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Архангай аймгийн Цагдаагийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Архангай аймгийн Цагдаагийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Т.БАЙГАЛМАА



2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31 өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	225,441,619.64	177,274,160.70
35	БАРАА МАТЕРИАЛ	225,441,619.64	177,274,160.70
35100	Түүхий эд материал	99,274,590.95	94,960,249.27
35110	Тусгай зориулалттай материал	98,646,454.95	94,484,060.70
35130	Эм боох материал	628,136.00	476,188.57
35300	Бэлэн бүтээгдэхүүн	68,000.00	68,000.00
35400	Хангамжийн материал	112,688,084.69	68,049,372.43
35410	Бичиг хэргийн материал	17,916,306.00	4,922,569.99
35420	Аж ахуйн материал	4,440,932.70	4,619,632.70
35430	Сэлбэг хэрэгсэл	57,739.00	57,739.00
35440	Түлш, шатах тослох материал	24,034,358.30	0.00
35460	Хүнсний материал	999,668.51	298,527.51
35470	Бусад хангамжийн материал	65,239,080.18	58,150,903.23
35600	Мал амьтад	13,410,944.00	14,196,539.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	3,109,009,637.68	3,057,042,569.56
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,109,009,637.68	3,057,042,569.56
39200	Биет хөрөнгө	2,998,200,198.48	2,945,164,610.16
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,571,890,555.39	2,571,890,555.39
39202	Хуримтлагдсан элэгдэл	-198,532,698.00	-271,722,040.08
39203	Авто-тээврийн хэрэгсэл	442,864,855.67	533,334,966.91
39204	Хуримтлагдсан элэгдэл	-147,920,492.88	-211,541,370.66
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	431,617,572.82	445,834,859.37
39206	Хуримтлагдсан элэгдэл	-171,788,984.51	-184,496,262.20
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	60,176,771.31	59,875,062.31
39208	Хуримтлагдсан элэгдэл	-26,264,237.35	-34,017,616.95
39211	Батлан хамгаалах, цэргийн зориулалттай тоног төхөөрөмж	34,765,656.00	34,765,656.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	1,504,000.00	1,504,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-112,799.97	-263,199.93
39300	Биет бус хөрөнгө	110,809,439.20	111,877,959.40
39301	Програм хангамж	1,100,919.00	1,100,919.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-481,479.80	-412,959.60
39303	Бусад биет бус хөрөнгө	110,190,000.00	111,190,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	3,334,451,257.32	3,234,316,730.26
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	3,334,451,257.32	3,234,316,730.26
51	Засгийн газрын хувь оролцоо	3,334,451,257.32	3,234,316,730.26
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,216,503,662.04	1,217,503,662.04
51200	Хуримтлагдсан үр дүн	1,552,904,382.77	1,451,769,855.71
51210	Өмнөх үеийн үр дүн	1,564,062,014.30	1,552,904,382.77
51220	Тайлант үеийн үр дүн	-11,157,631.53	-101,134,527.06
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	565,043,212.51	565,043,212.51
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	3,334,451,257.32	3,234,316,730.26

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31 өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,887,055,194.24	3,067,234,302.57
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	340,426,034.24	333,030,652.57
120	Нийтлэг татварын бус орлого	340,426,034.24	313,530,652.57
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	155,715,952.00	212,503,888.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	84,377,039.00	91,664,028.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	71,338,913.00	120,839,860.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	155,700,439.74	89,422,394.57
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	29,009,642.50	11,604,370.00
122	Тусламжийн орлого	0.00	19,500,000.00
122001	Хандив тусламж /дотоод/	0.00	19,500,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,546,629,160.00	2,734,203,650.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,441,623,200.00	2,687,165,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,441,623,200.00	2,687,165,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	105,005,960.00	47,038,550.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	11,350,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	105,005,960.00	35,688,550.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,898,102,825.77	3,168,368,829.63
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,898,102,825.77	3,168,368,829.63
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,886,769,953.77	3,130,491,925.63
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,090,260,039.00	2,307,148,300.00
210101	Үндсэн цалин	1,147,952,464.00	1,143,490,944.00
210102	Нэмэгдэл	936,878,381.00	1,106,388,205.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0.00	22,520,000.00
210105	Гэрээт ажлын хөлс	5,429,194.00	34,749,151.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	44,912,538.00	48,634,700.00
210201	Тэтгэврийн даатгал	2,580,390.00	1,887,687.00
210202	Тэтгэмжийн даатгал	367,675.00	362,389.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	243,742.00	171,587.00
210204	Ажилгүйдлийн даатгал	60,936.00	42,897.00
210205	Эрүүл мэндийн даатгал	41,659,795.00	46,170,140.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	117,420,432.00	121,064,200.00
210301	Гэрэл, цахилгаан	13,651,123.00	14,156,922.00
210302	Түлш, халаалт	99,047,083.00	99,084,880.00
210303	Цэвэр, бохир ус	4,722,226.00	7,822,398.00
2104	Хангамж, бараа материалын зардал	168,203,317.40	210,280,944.40
210401	Бичиг хэрэг	17,180,772.00	19,370,929.00
210402	Тээвэр, шатахуун	111,757,161.00	147,449,358.30
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	13,913,000.00	14,184,063.00
210404	Ном, хэвлэл	103,120.00	0.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	327,000.00	315,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,548,350.00	4,478,652.20
210408	Бараа материал ақталсны зардал	17,373,914.40	24,482,941.90
2105	Нормативт зардал	31,834,044.98	29,822,508.43
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	397,564.00	205,947.43

Архангай аймгийн Цагдаагийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

210502	Хоол, хүнс	30,793,480.98	28,408,561.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	643,000.00	1,208,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	59,707,283.00	69,890,090.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	0.00	568,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	4,925,416.00	17,215,520.00
210604	Урсгал засвар	54,781,867.00	52,106,570.00
2107	Томилолт, зочны зардал	19,740,000.00	20,955,000.00
210702	Дотоод албан томилолт	19,740,000.00	20,955,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	21,395,993.00	19,408,648.01
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	17,300,392.00	17,257,500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	800,000.00	0.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	2,236,253.00	910,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	660,000.00	660,000.00
210807	Газрын төлбөр	265,796.00	400,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	133,552.00	181,148.01
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	333,296,306.39	303,287,534.79
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,444,400.00	2,759,856.60
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,888,655.75	3,500,590.50
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	321,963,250.64	297,027,087.69
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	11,332,872.00	37,876,904.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	10,728,610.00	11,080,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	500,000.00	500,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	10,228,610.00	10,580,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	604,262.00	26,796,904.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	604,262.00	26,796,904.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	-11,047,631.53	-101,134,527.06
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	110,000.00	0.00
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	110,000.00	0.00
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-11,157,631.53	-101,134,527.06

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31 өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,194,833,662.04	576,542,396.51	1,552,562,830.30	3,323,938,888.85
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	11,499,184.00	11,499,184.00
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,194,833,662.04	576,542,396.51	1,564,062,014.30	3,335,438,072.85
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.00	-11,499,184.00	0.00	-11,499,184.00
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	21,670,000.00	0.00	0.00	21,670,000.00
9	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-11,157,631.53	-11,157,631.53

10	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,216,503,662.04	565,043,212.51	1,552,904,382.77	3,334,451,257.32
11	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,216,503,662.04	565,043,212.51	1,552,904,382.77	3,334,451,257.32
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,216,503,662.04	565,043,212.51	1,552,904,382.77	3,334,451,257.32
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	1,000,000.00	0.00	0.00	1,000,000.00
19	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-101,134,527.06	-101,134,527.06
20	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	1,217,503,662.04	565,043,212.51	1,451,769,855.71	3,234,316,730.26

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31 өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	2,631,006,199.00	2,825,868,554.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	84,377,039.00	91,664,904.00
120	Нийтлэг татварын бус орлого	84,377,039.00	91,664,904.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	84,377,039.00	91,664,904.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	84,377,039.00	91,664,904.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,546,629,160.00	2,734,203,650.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,441,623,200.00	2,687,165,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,441,623,200.00	2,687,165,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	105,005,960.00	47,038,550.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	11,350,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	105,005,960.00	35,688,550.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,564,351,699.00	2,805,270,554.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,564,351,699.00	2,805,270,554.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,553,018,827.00	2,767,393,650.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,084,386,677.00	2,307,148,300.00
210101	Үндсэн цалин	1,148,906,200.00	1,215,527,900.00
210102	Нэмэгдэл	903,586,500.00	1,032,757,900.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0.00	22,520,000.00
210105	Гэрээт ажлын хөлс	31,893,977.00	36,342,500.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	50,785,300.00	48,634,700.00
210201	Тэтгэврийн даатгал	2,587,195.00	2,037,593.00
210202	Тэтгэмжийн даатгал	283,622.00	214,484.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	226,900.00	171,587.00
210204	Ажилгүйдлийн даатгал	56,725.00	42,897.00
210205	Эрүүл мэндийн даатгал	47,630,858.00	46,168,139.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	117,420,432.00	121,064,200.00
210301	Гэрэл, цахилгаан	13,651,123.00	14,156,922.00
210302	Түлш, халаалт	99,047,083.00	99,084,880.00
210303	Цэвэр, бохир ус	4,722,226.00	7,822,398.00
2104	Хангамж, бараа материалын зардал	159,493,730.00	157,813,800.00
210401	Бичиг хэрэг	19,061,980.00	17,861,219.00
210402	Тээвэр, шатахуун	121,858,930.00	119,350,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	13,913,000.00	13,923,063.00
210404	Ном, хэвлэл	103,120.00	120,000.00

Архангай аймгийн Цагдаагийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	656,700.00	315,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,900,000.00	6,244,518.00
2105	Нормативт зардал	29,589,100.00	29,180,100.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	200,000.00	300,000.00
210502	Хоол, хүнс	28,389,100.00	27,573,100.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,000,000.00	1,307,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	57,501,647.00	58,394,850.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	4,000,000.00	9,441,050.00
210604	Урсгал засвар	53,501,647.00	48,953,800.00
2107	Томилолт, зочны зардал	19,740,000.00	20,955,000.00
210702	Дотоод албан томилолт	19,740,000.00	20,955,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	20,785,941.00	19,227,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	16,823,892.00	17,257,500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	800,000.00	0.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	2,236,253.00	910,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	660,000.00	660,000.00
210807	Газрын төлбөр	265,796.00	400,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	13,316,000.00	4,975,200.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,585,800.00	1,680,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,730,200.00	3,295,200.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	11,332,872.00	37,876,904.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	10,728,610.00	11,080,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	500,000.00	500,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	10,228,610.00	10,580,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	604,262.00	26,796,904.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	604,262.00	26,796,904.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	66,654,500.00	20,598,000.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	66,654,500.00	20,598,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	66,654,500.00	20,598,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	66,654,500.00	20,598,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	66,654,500.00	20,598,000.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-66,654,500.00	-20,598,000.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	0.00	0.00
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31 өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,752,033,100.00	2,752,033,100.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,752,033,100.00	2,752,033,100.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,748,253,100.00	2,748,253,100.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,307,148,300.00	2,307,148,300.00
210101	Үндсэн цалин	1,215,527,900.00	1,215,527,900.00

Архангай аймгийн Цагдаагийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

210102	Нэмэгдэл	1,055,277,900.00	1,032,757,900.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0.00	22,520,000.00
210105	Гэрээт ажлын хөлс	36,342,500.00	36,342,500.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	48,634,700.00	48,634,700.00
210201	Тэтгэврийн даатгал	0.00	2,037,593.00
210202	Тэтгэмжийн даатгал	0.00	214,484.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	0.00	171,587.00
210204	Ажилгүйдлийн даатгал	0.00	42,897.00
210205	Эрүүл мэндийн даатгал	48,634,700.00	46,168,139.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	121,064,200.00	121,064,200.00
210301	Гэрэл, цахилгаан	13,803,600.00	14,156,922.00
210302	Түлш, халаалт	102,463,700.00	99,084,880.00
210303	Цэвэр, бохир ус	4,796,900.00	7,822,398.00
2104	Хангамж, бараа материалын зардал	157,638,800.00	157,638,800.00
210401	Бичиг хэрэг	17,862,000.00	17,861,219.00
210402	Тээвэр, шатахуун	119,183,800.00	119,175,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	13,913,000.00	13,923,063.00
210404	Ном, хэвлэл	120,000.00	120,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	660,000.00	315,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,900,000.00	6,244,518.00
2105	Нормативт зардал	28,223,100.00	28,223,100.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	300,000.00	300,000.00
210502	Хоол, хүнс	27,173,100.00	27,173,100.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	750,000.00	750,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	58,333,800.00	58,333,800.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	5,380,000.00	5,380,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	4,000,000.00	4,000,000.00
210604	Урсгал засвар	48,953,800.00	48,953,800.00
2107	Томилолт, зочны зардал	19,740,000.00	19,740,000.00
210702	Дотоод албан томилолт	19,740,000.00	19,740,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,470,000.00	5,470,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,500,000.00	3,500,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	910,000.00	910,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	660,000.00	660,000.00
210807	Газрын төлбөр	400,000.00	400,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,000,200.00	2,000,200.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,000,200.00	2,000,200.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,780,000.00	3,780,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,780,000.00	3,780,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	500,000.00	500,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,280,000.00	3,280,000.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,752,033,100.00	2,778,830,004.00
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,687,165,100.00	2,687,165,100.00
310001	Улсын төсвөөс санхүүжих	2,687,165,100.00	2,660,368,196.00
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	64,868,000.00	91,664,904.00
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	64,868,000.00	91,664,904.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	149	141
620001	Удирдах ажилтан	1	1
620002	Гүйцэтгэх ажилтан	145	137
620003	Үйлчлэх ажилтан	3	3

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31 өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	47,038,550.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	47,038,550.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	39,738,550.00
2104	Хангамж, бараа материалын зардал	175,000.00
210401	Бичиг хэрэг	
210402	Тээвэр, шатахуун	175,000.00
2105	Нормативт зардал	957,000.00
210502	Хоол, хүнс	400,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	557,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	20,659,050.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	15,218,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	5,441,050.00
2107	Томилолт, зочны зардал	1,215,000.00
210702	Дотоод албан томилолт	1,215,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	13,757,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	13,757,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,975,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,680,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,295,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	7,300,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	7,300,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	7,300,000.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	47,038,550.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	47,038,550.00
131103	ЗГНХ, ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	11,350,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	35,688,550.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Архангай аймгийн Цагдаагийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд үйл ажиллагааны орлоготой холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор П.Энхжаргал гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Нэргүйбаатар, дарга, тэргүүлэх аудитор Т.Байгалмаа нар тус тус хэрэгжүүлсэн.

Архангай аймгийн Цагдаагийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 27/451 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Архангай аймгийн Цагдаагийн газар нь Цагдаагийн албаны тухай хуулийн 4.1-д заасны дагуу "... гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үндсэн чиг үүргийг хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд хэрэгжүүлэх төрийн тусгай алба" юм.

Тус байгууллага нь тайлант онд "Удирдах ажилтны манлайлал, алба хаагчдын мэдлэг ур чадвар дээшлүүлэх аюулгүй байдал хууль ёсны эрх ашгийг хамгаалах" гэсэн зорилт тавин ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоол "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай"
- ЗГ-ын 2021 оны 124 дүгээр тогтоол "Босго үнэ шинэчлэн батлах тухай";
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар"

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэхэд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тайлант оны санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтаар Санхүү, аж ахуйн албанаас 2021 оны 5 дугаар сарын 07-ны өдрийн 6/742 дугаар зөвлөмж, мөн ЦЕГ-н даргын 2021 оны 3 дугаар сарын 02-ны өдрийн 02 дугаар албан даалгаврын биелэлтийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажилласан байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитороос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Архангай аймгийн Цагдаагийн газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлсөн, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Мөн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсөв 2,532.3 сая төгрөгөөс 1 хувиар буюу 25.3 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувь буюу 19.0 сая төгрөгөөр тогтоосон.

Харин гүйцэтгэлийн үе шатанд батлагдсан төсөв 2,752.0 сая төгрөг болж 219.7 сая төгрөгөөр өссөн тул шинэчлэн тогтоосон материаллаг байдлыг 27.5 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувь буюу 20.6 сая төгрөгөөр тогтоолоо.

3.5 САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

Тус байгууллагын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаар нийт хөрөнгийн дүн эхний үлдэгдлээс 100.1 сая төгрөгөөр буюу 3.0 хувиар буурсан нь бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт	Хувь
Б	1	2	3=2-1	
Бараа материал	225.4	176.8	-48.6	-21.6
Үндсэн хөрөнгө	3,109.0	3,057.5	-51.5	-1.7
Нийт хөрөнгө	3,334.4	3,234.3	-100.1	-3.0
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	3,334.4	3,234.3	-100.1	-3.0
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	3,334.4	3,234.3	-100.1	-3.0

Дансны үлдэгдэлд гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- *Бараа материалын үлдэгдэл өмнөх оноос 21.6 хувиар буурсан байна.*

Бараа материалын данс нь 225.4 сая төгрөгийн эхний үлдэгдэлтэй ба тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдан авсан 242.3 сая төгрөг, бусад байгууллагаас үнэ төлбөргүй хүлээн авсан 14.2 сая төгрөг, малын нас дэвшлийн 9.0 сая төгрөг нийт 265.5 сая төгрөгөөр нэмэгдэж, тайлант онд зарцуулсан 283.8 сая төгрөг, акталж устгасан 30.3 сая төгрөг нийт 314.1 сая төгрөгөөр хасагдаж, эцсийн үлдэгдэл 176.8 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

- *Үндсэн хөрөнгийн үлдэгдэл өмнөх оноос 1.7 хувиар буурсан байна.*

Үндсэн хөрөнгө данс нь 3,109.0 сая төгрөгийн эхний үлдэгдэлтэй ба тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдаж авсан 20.6 сая төгрөгөөр нэмэгдэж, үнэ төлбөргүй 224.9 сая төгрөгийн хөрөнгө хүлээн авч нийт 245.5 сая төгрөгөөр нэмэгдэж, тайлант хугацаанд байгуулсан 297.0 сая төгрөгийн элэгдлийн дүнгээр буурч, 3,057.5 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

- *Засгийн газрын хувь оролцоо 3.0 хувиар буурсан байна.*

Цэвэр хөрөнгө өмчийн дүн 3,234.3 сая төгрөг байгаа нь тайлант хугацааны үр дүн 100.1 сая төгрөгөөр буурсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Санхүүгийн үр дүнгийн тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	/сая.төгрөг/
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,441.6	2,687.2	245.6
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	84.3	91.7	7.4
Нэмэлт санхүүжилтийн орлого	105.0	47.0	-58.0
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	256.1	241.3	-14.8
Үйл ажиллагааны орлого	2,887.0	3,067.2	180.2
Цалин, шимтгэлийн зардал	2,090.3	2,301.1	210.8
Бусад бараа үйлчилгээний зардал	453.1	538.2	85.1
Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	21.4	19.3	-2.1
Бараа үйлчилгээний бусад зардал	333.3	309.7	-23.6
Үйл ажиллагааны зардал	2,898.1	3,168.3	270.2
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-11.1	-101.1	-90.0

Цагдаагийн газрын санхүүгийн үр дүнгийн тайлангийн урсгал үйл ажиллагааны санхүүжилтийн орлого өмнөх оноос 245.6 сая төгрөг буюу 10.1 хувиар өссөн нь нийт бүрэлдэхүүний цалингийн шатлал МУЗГ-ын 2019 оны 472 дугаар тогтоол, ЦБҮАЖ 924-д заасны дагуу ТТ-8 болж өөрчлөгдсөнтэй холбоотой байна. Төлөвлөсөн санхүүжилтийг зарцуулж ажилласан байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр, нийт зарлагыг 2,611.1 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсөв захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг нийт 140.9 сая төгрөгөөр нэмэгдүүлж нийт зардлыг 2,752.0 сая төгрөгөөр хянаж баталсан нь Монгол улсын засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоолоор алба хаагчдын цалин нэмэгдсэнтэй холбоотой байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 3 арга хэмжээг хэрэгжүүлэхэд 2,687.2 сая төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр бүрэн зарцуулсан байна. Харин үйл ажиллагааны орлогыг 64.9 сая төгрөгөөр төлөвлөж 91.7 сая төгрөг төвлөрүүлж 26.8 сая төгрөгөөр давуулан биелүүлснийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант жилд нэмэлт санхүүжилтийн дансаар Архангай аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн 2021 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн тушаалаар Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтийн зардалд 19.7 сая төгрөгийн санхүүжилт олгосныг компьютер тоног төхөөрөмж, сургалтын зардалд, засаг даргын нөөц сангаас 11.5 сая төгрөгийн санхүүжилт олгосныг 100 жилийн ойн арга хэмжээний ном хэвлүүлэх зардал, "БИ...БАЙНА" арга хэмжээний зардалд, Эрдэнэбулган сумын ИТХ-аас 6.9 сая төгрөгийн санхүүжилт олгосныг компьютер тоног төхөөрөмж, олон нийтийн цагдаагийн хувцас хэрэглэл, саналын хайрцаг хийлгэх зардалд, галт зэвсгийн сургалтаар 3.5 сая төгрөгийн орлого олсныг тухай сургалтын зардалд, Онцгой байдлын газраас 5.4 сая төгрөгийн санхүүжилт ирснийг алба хаагчдын дархлаажуулалтад зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Монгол улсад орчин цагийн цагдаагийн байгууллага үүсэж хөгжсний 100 жилийн ойг тэмдэглэх арга хэмжээнд орон нутгийн дэмжлэгээр дурсгалт альбом хэвлүүлэх зардалд 8.4 сая төгрөгийг зарцуулж, баярын хурал хийж алба хаагчдыг төрийн дээд одон медаль болон Цагдаагийн байгууллагын ойн медалиар шагнаж урамшуулсан байна.

3.8 Аудитын ГОЛ АСУУДАЛ

Тус байгууллага нь жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан стратегийн зорилтуудыг хангахад чиглэсэн 5 үндсэн зорилтын хүрээнд 36 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилт 82.5 хувьтай байна.

Тайлант онд хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээнд зориулан нийт 2,572.0 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөж, гүйцэтгэлээр нийт 2,572.0 сая төгрөгийг зарцуулж, 100 хувийн биелэлттэй байна.

Аудитын явцад санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэлийн дагуу дараах судалгааг авч үнэллээ. Үүнд:

- Албан хаагчдын үр дүнгийн урамшуулалд 15.1 сая төгрөг, албан томилолтын зардалд 20.9 сая төгрөг, бусад тогтмол зардлуудыг батлагдсан төсвийн хүрээнд зарцуулсан байна.
- Цагдаагийн газар нь төрийн тусгай чиг үүргийн байгууллага тул Засгийн газрын 2021 оны 43 дугаар "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" тогтоолд хамаарахгүй бөгөөд батлагдсан төсвийн хүрээнд зардлыг зарцуулсан байна.
- Суудлын автомашин ашиглалтын хувьд: Цагдаагийн газар нь нийт 48 тээврийн хэрэгсэлтэй бөгөөд 533.3 сая төгрөгийн анхны өртөгтэй, шатахууны зардалд 147.4 сая төгрөг, сэлбэг хэрэгслийн зардалд 35.7 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна. Орон тооны 7 жолоочтой, жолооч нарын цалинд 95.1 сая төгрөгийг олгожээ.

Харин бусад судалгаанд холбогдох мэдээлэлгүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байдаг.

Санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны тухай хууль, “Төсвийн хэмнэлтийн талаар зарим арга хэмжээний тухай” засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг шалгахад зөрчил илрээгүй.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Архангай аймгийн Цагдаагийн газар нь 2021 онд нийт 2,699.4 сая төгрөгийн 146 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст хугацаанд нь ил тод мэдээлсэн байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Цагдаагийн газар нь тусгай чиг үүргийн байгууллага тул Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1 дэх заалт хамааралгүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, бусад хууль тогтоомжийн хүрээнд Монгол Улсын Засгийн газрын “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын хэрэгжилт холбогдох шалгуурт нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар бусдаар гүйцэтгүүлэх зардлаас шинжээчийн хөлс олгосон байдлыг шалгахад МУЗГ-ын 2018 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн 161 дүгээр тогтоолын дагуу шинжээчийн ажлын хөлсийг олгоогүй, журмыг хэрэгжүүлж ажиллаагүй харилцагч байгууллагын нэхэмжилсэн дүнгээр харилцан адилгүй олгосон, мөн албан томилолтын зардлыг давтан тооцоолж анхан шатны баримтаар тулган хянахад 2020 оны 10 дугаар сард Орхон аймагт Хөл бөмбөгийн тэмцээнд оролцохоор явсан 14 албан хаагчийн томилолтын зардлыг 1 хоногоор илүү тооцож олгосон зэрэг зөрчлүүдэд зөвлөмж хүргүүлснийг 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар анхан шатны баримтаар тулган шалгахад дээрх зөрчлийг арилгасан байх тул зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлэн ажилласан байна гэж үзлээ.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарал татахуйц өөр асуудал байхгүй.

-----oOo-----